Тайлант онд оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг албаны даргын 2021 оны 03-р сарын 25-ны өдрийн А/23 тоот тушаалын дагуу 5 лаборатори 2 төв, 1 хэлтэст эд хөрөнгийн тооллого хийж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан дахь дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын 36,526.5 мянган төгрөгөөс 70 хувиар буюу 25,568.6 мянган төгрөгөөр тогтоосон ба төлөвлөлтийн үе шатны ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатны үед дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт үзүүлэлт өмнөх оноос 1,706,276.6 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар буурсан боловч бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10.0	10.0	0.0
Бараа материал	642,246.5	500,044.9	142,201.7
Үндсэн хөрөнгө	13,169,412.5	11,636,792.5	1,532,619.9
Нийт хөрөнгө	13,843,124.1	12,136,847.4	1,706,276.6
Засгийн газрын оролцоо/эздийн өмч/	2,560,500.8	2,560,500.8	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	13,843,124.1	12,136,847.4	1,706,276.6

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл нь 500,044.9 мянган төгрөг болж 142,201.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос эм боох материал дансны үлдэгдэл 44,309.8 мянган төгрөгөөр өссөн; сэлбэг хэрэгсэл дансны үлдэгдэл 45,771.7 мянган төгрөгөөр буурсан, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 110,765.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь тайлант онд 11,636,792.5 мянган төгрөг болж 1,532,619.9 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмжийн элэгдэл дансны үлдэгдэл 1,289,985.7 мянган төгрөгөөр өссөнтэй голчлон холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,969,575.7 мянга, зарлагыг 3,969,575.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,297,274.2 мянган төгрөгөөр бууруулж 2,672,301.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 2 удаагийн тодотгол хийгдэж нийт 57,959.5 мянган төгрөгөөр хасч 2,730,261.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэх 2,417,306.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 312,955.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,417,306.0 мянган төгрөгийн санхүүжигдэн, үйл ажиллагааны орлогоос 1,165,709.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсөвт 6,844.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зардлыг 6,844.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагаа 5,743.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 975.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
	70417	Мэргэжлийн хяналт	2,730,261.0	2,719,416.7	10,844.2	99.60%
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,620,397.7	2,609,988.0	10,709.7	99.59%
2	80227	Лабораторын итгэмжлэл	21,341.10	21,331.50	9.6	99.95%
3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	88,522.20	88,397.20	125.0	99.85%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 4,148.5 мянган төгрөгний орлого хүлээн авснаас урьд оны төрийн сангаас авах авлага 4,000.0 мянган төгрөг, Тэнгэр Даатгал ХХК-аас тээврийн хэрэгслийн даатгал 148.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс 4,000.0 мянган төгрөгийг эмийн лабораторын цалингийн зардалд зарцуулж, төрийн санд 148.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус лаборатори хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай.

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.6 хувийн биелэлттэй, 0.4 хувь буюу 6,844.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 0.4 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татсан асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 17 мэдээлэл, байршуулаагүй 1 мэдээлэл байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 27 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь нийт 706,720.2 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 593,264.6 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл

Аудитын код: АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ

ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 14,000.0 мянган төгрөгний “GC-MC Thermofisher co.itd Filament Assembly dual” гэх сэлбэгийг төсвөөс шууд худалдан авсан байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2013 оны 03 дугаар сарын 02-ны Засгийн газрын 68 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалт хийсэн зөрчил юм.

Шийдвэрлэсэн нь: “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолыг тус тус мөрдөн ажиллах, албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, сэлбэг хэрэгсэлийн худалдан авалт нь “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2013 оны 03 дугаар сарын 02-ны Засгийн газрын 68 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах байдалтай байна.

Нийт 55,470.0 мянган төгрөгний албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	23,543.7	1	23,543.7	-	-	100
Зөвлөмж	1	31,926.3	1	31,926.3	-	-	100
Нийт дүн	2	55,470.0	2	55,470.0	-	-	100

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоол, Шадар сайдын 2021 оны 94 дүгээр тушаалын дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лаборатори буюу эм, эмнэлгийн хэрэгслийг шинжлэх үйл ажиллагааг эрхлэн явуулахаар тохируулагч агентлагийн харьяанд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр шилжүүлсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,238,306.4 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 161,705.80 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,076,600.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1,076,600.6 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 1,051,032.0 мянган төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдааг залруулан баталгаажуулав. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас авсан бараа материал 19,984.3 мянга, үндсэн хөрөнгө 161,705.8 мянга, нийт 181,690.1 мянган төгрөгийн хөрөнгийг 120017-Үнэ төлбөргүй орлого-Бараа материал дансанд бүртгэснийг залруулан 1200018-Үнэ төлбөргүй орлого-үндсэн хөрөнгө, 120017-Үнэ төлбөргүй орлого-Бараа материал данс тус бүрт ангилан залруулав.

4.2 Албан шаардлага

1. Тайлант онд Аж ахуй нэгж, хувь хүнээс 64,813.6 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй, 1,011,787.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны буюу шинжилгээний орлогодоо НӨАТ-ын төлбөрийн цахим баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалт, борлуулалтыг тухай бүрэн хянаж, бүртгэн ажиллах, Албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

Анхаарвал зохих асуудлын тухай:

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч эвдэрч гэмтсэн үйл ажиллагааны болон хоцрогдолын элэгдэлд орсон 133 нэрийн 1,524,236.6 мянган төгрөгний хөрөнгийг данснаас хасах талаар зохих арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ХАБҮЛЛ	АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ	МХЕГ-аас авсан 19,984.3 мянган төгрөгийн бараа материал, 161,705.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн нийт 181,690.1 мянган төгрөгийн хөрөнгийг 120017-Үнэ төлбөргүй орлого-Бараа материал дээр авсан байсан.	1200018-Үнэ төлбөргүй орлого-үндсэн хөрөнгө, 120017-Үнэ төлбөргүй орлого-Бараа материал данс руу тус тус ангилан бүртгүүлэв.	1	161,705.8	1	161,705.8								
2	ХАБҮЛЛ	АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ	Тайлант онд ААН, хувь хүнээс 64,813.6 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна. Мөн 1,011,787.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны буюу шинжилгээний орлогодоо НӨАТ-ын төлбөрийн цахим баримтаа шивээгүй байна.	Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах	1	1,076,600.6					1	1,076,600.6				

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ХАБУЛЛ	АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ	Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч эвдэрч гэмтсэн үйл ажиллагааны болон хоцрогдолын элэгдэлд орсон 133 нэрийн 1,524,236.6 мянган төгрөгний хөрөнгийг данснаас хасах талаар зохих арга хэмжээ авч ажиллаагүй байна.	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.												
Дүн					2	1,238,306.4	1	161,705.80	-	-	1	1,076,600.60	0	0	0	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
4	ХАБУЛЛ	АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд ил тод болгоогүй	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	1	593,264.6					1	593,264.6				
5	ХАБУЛЛ	АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Босго үнэ шинэчлэн батлах тухай хууль-ийн дагуу шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан үнийн дүнтэй барааг шууд худалдан авсан/2021.03.01 өдөр/	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Босго үнэ шинэчлэн батлах тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах.	1	14,000.0					1	14,000.0				
Дүн					2	607,264.6	0	0	0	0	2	607,264.6	0	0	0	0
Нийт дүн					4	1,845,571.0	1	161,705.8	-	-	3	1,683,865.2	-	-	0	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 199/А0150058
АХГ-2022/155/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 14,000,000.0 мянган төгрөгний "GC-MC Thermofisher co.itd Filament Assembly dual" нэртэй төсвөөс шууд худалдан авч бүртгэсэн байна.

Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль", Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 2013 оны 68 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан үнийн дүнгээс давсан худалдан авсан зөрчил байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль", "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын тогтоолыг тус тус мөрдөн ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газар ирүүлнэ үү.
2. Цаашид алдаа зөрчлийг давтах гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн албаны дарга Б.Амар, Ерөнхий нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭВИДЕНС АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.ШҮРЭНЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 198/А0150058
АХГ-2022

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь нийт 706,720,023.11 төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 593,264,600.0 төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлнэ үү.
2. Цаашид алдаа зөрчлийг давтах гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн албаны дарга Б.Амар, Ерөнхий нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭВИДЕНСЕ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

(Handwritten signature)

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Д.ШҮРЭНЦЭЦЭГ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-192.Docx

0010800019



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 197/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/155/МА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд аж ахуй нэгж, хувь хүнээс 64,813,600.0 төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт аваагүй байна. Мөн 1,011,786,984.0 төгрөгийн үйл ажиллагааны букуу шинжилгээний орлогод НӨАТ-ын төлбөрийн цахим баримт бүртгээгүй зөрчилтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын ажил, гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах татварын цахим системээр худалдан авалт, борлуулалтыг тухай бүрэн хянаж, бүртгэн ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтах гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн албаны дарга Б.Амар, Ерөнхий нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭВИДЕНС АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Д.ШҮРЭНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\10.10.10.20\B\chig_kheres\Alban_Shardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-193.Docx

00108C0E??2

